

XIX зүйл ба эрх зүйн орчин

Х. Наранжаргал, “Глоб Интернэшнл” ТББ-ын тэргүүн

Энэ өдрүүдэд дэлхий нийтээрээ Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын 60 жилийн ойг тэмдэглэж байна. 1948 оны 12-р сарын 10-нд НҮБ-ын Ерөнхий Ассемлейн Анхдугаар Чуулганы 217 А (III) тоот тогтоолоор батлан тунхагласан энэ түүхэн бичиг баримтыг бүрэн эхээр нь, улс орны улс төрийн тогтолцоо, газар нутгаас үл хамааран, хүн бүрт түгээн дэлгэрүүлэх, дунд сургууль, боловсролын бусад байгууллагад суралцагсдад таниулан мэдүүлэхийг гишүүн орнууддаа уриалсан юм.

Монгол Улс 1964 онд НҮБ-ын гишүүн болж, хүний үндсэн эрхүүдийг тунхагласан энэ чухал баримт бичгийг хүлээн зөвшөөрсөн билээ.

Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын XIX зүйлээр хүн бүр үзэл бодолтой байж, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхийг тунхагласан байдаг. Мөн “үзэл санаа, мэдээллийг улсын хилийн заагаар үл хязгаарлан боломжтой аргаар эрж сурвалжлах, олж ашиглах, түгээн дэлгэрүүлэх эрх багтана” хэмээн тунхаглажээ.

Манай улс Үндсэн Хуулиараа Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын XIX зүйлийг баталгаажуулж, иргэдийнхээ итгэл үнэмшил, үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх, хэвлэн нийтлэх, мэдээлэлтэй байх эрхийг тунхагласан билээ.

1998 онд Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль, 2005 онд Олон нийтийн радио, телевизийн тухай хууль баталж, Эрүүгийн хууль, бүх шатны сонгуулийн тухай хууль, Зар сурталчилгааны тухай зэрэг зарим хуулийн зарим зүйл заалтаар хэвлэл мэдээллийн үйл ажиллагааг зохицуулсан байдаг.

Гэсэн хэдий ч үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин төдийлөн таатай бус байна.

- Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулиар хориглосон цензур бодитой төдийгүй хэвлэл мэдээллийн хэрэгслэлийн өмчлөл, санхүүжилт, удирдлагаар дамжин нөлөөлдөг, өөр хэлбэрийн шууд, хатуу цензур болжээ. Ялангяа сэтгүүлчдийн өөрийн цензур өндөр байна. Энэ хуулийн төр хэвлэл мэдээллийн хэрэгсэл эзэмшихийг хориглосон заалт ч зөрчигдсөөр байна.
- Иргэдийн мэдээлэлтэй байх эрх тунхагийн төдий, амьдрал дээр хязгаарлалт нь түлхүү байна. Энэ хязгаарлалт нь Төрийн нууцын тухай хууль, төрийн нууцын жагсаалтын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хууль, бараг хууль бүрийн нууцыг хадгалах зүйл заалт илэрдэг. 2007 онд манай хуульчдын хийсэн судалгаанаас харахад, 360 орчим хуулийн 129-д нь (36%) мэдээлэл ил тод, нээлттэй байх зүйл заалт байдаг.
- Сонгогдсон эрх мэдэлтэн, өндөр албан тушаалтнууд Иргэний Хууль, Эрүүгийн хуулийн нэр төр, гүтгэлэг, доромжлолтой холбоотой зүйлийг цензур болгон ашигладаг.

Сүүлийн хэдэн жил ЮНЕСКО-гийн ажлын хэсэг хэвлэл мэдээллийн салбарыг хөгжүүлэхэд нөлөө бүхий хүчин зүйлүүдийг тодорхойлж, хөгжил дэвшлийг

үнэлэх 50 гол, 194 туслах үзүүлэлтийг багтаажээ. Судалгааны үр дүнд хэвлэл мэдээллийн таван ангилалд 21 асуудлыг багцлан томъёолсон байна. Үүнд:

- 1) **Үзэл бодлоо илэрхийлэх, олон ургальч байдал, хэвлэл мэдээлэл янз бүрийн байхыг илэрхийлсэн зохицуулалтын тогтолцоо**
 - a. Эрх зүй, улс төрийн хүрээ
 - b. **Өргөн** нэвтрүүлгийн зохицуулалтын тогтолцоо
 - c. Гүтгэлэг, нэр төртэй холбоотой хууль, эрх зүйн бусад хязгаарлалт
 - d. Цензур
- 2) **Хэвлэл мэдээлэл олон ургальч байдал, янз бүр байх, эдийн засгийн орчин, өмчлөлийн ил тод байдал**
 - a. Хэвлэл мэдээллийн бөөгнөрөл
 - b. Олон нийтийн, хувийн, хүй олны/Коммюнити хэвлэл мэдээллийн янз бүрийн холимог байдал
 - c. **Зөвшөөрөл**, цар хүрээний хуваарилалт
 - d. Татвар, бизнесийн зохицуулалт
 - e. Зар сурталчилгаа
- 3) **Хэвлэл мэдээлэл ардчилсан яриа хэлэлцүүлэг болох нь**
 - a. Хэвлэл мэдээлэл нийгмийн янз бүрийн байдлыг илэрхийлнэ
 - b. Олон нийтийн **өргөн** нэвтрүүлгийн загвар
 - c. Хэвлэл мэдээллийн **өөрийн** зохицуулалт
 - d. Шударга байх, тал тохой татахгүй байх
 - e. Олон нийтийн итгэл, найдвар
 - f. Сэтгүүлчдийн аюулгүй байдал
- 4) **Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, олон ургальч байдал, янз бүрийн байдлыг хөхиүлэн дэмжих байгууллагын мэргэжлийн түвшин, дэмжлэг**
 - a. Хэвлэл мэдээллийн мэргэжлийн сургалт бий эсэх
 - b. Хэвлэл мэдээллийн академик боловсрол олгож буй эсэх
 - c. Үйлдвэрчний эвлэл, мэргэжлийн эвлэл холбоод буй эсэх
 - d. Иргэний нийгмийн байгууллагууд бий эсэх
- 5) **Хараат бус, олон ургальч хэвлэл мэдээллийг дэмжих дэд бүтцийн түвшин**
 - a. Хэвлэл мэдээлэл техникийн **нөөц** боломжтой, түүний ашиглалт
 - b. Сонин хэвлэл, **өргөн** нэвтрүүлэг, мэдээллийн технологи нэвтэрсэн байдал

Дээр дурдсан үзүүлэлтээр манай хэвлэл мэдээллийн хөгжлийн түвшинг **өнгөц дүгнэвэл** бид заримыг орхигдуулсан, заримыг нь хэрэгсэхгүй байгаа, заримыг нь **үл** тоосон, заримыг оромдсон ч байх юм. Үүнд бид цаашдаа хамтын хүчээр анхаарал тавиасай.

Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын үзэл санаа, зарчмыг бүрэн, жинхэнэ утгаар нь хэрэгжүүлэхийн тулд цогц арга хэмжээ авах шаардлагатай нь харагдаж байна.

Бидний **өмнө** тулгарч буй зарим асуудлыг манай илтгэгчид **хөндөж** ярина. Үүнээс хараат бус хэвлэл мэдээлэл, хараат бус сэтгүүл зүй хаана байгааг тодорхойлох боломж бидэнд олдох байх.

Харин би эрх зүйн орчныг илүү боловсронгуй болгох зайлшгүй шаардлагатай тухай жаахан тодотгоё.

Юуны түрүүнд үзэл бодлоо илэрхийлэх, мэдээллийн эрх чөлөөг хязгаарлаж буй, ХЭТТ, Үндсэн Хуультай зөрчилдсөн хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт хийх, зарим хуулийг шинээр батлах шаардлагатай байгаа юм. Тухайлбал,

- Нууц хамгаалсан хууль, зарим хуулийн зүйл заалтыг ХЭТТ, ялангуяа мэдээллийн эрх чөлөөний олон улсын хэмжээний үзэл санаанд нийцүүлэн өөрчлөх, зарим хуулийг хүчингүй болгох
- Мэдээлэл авах эрх, эрх чөлөөний тухай хуулийг яаралтай батлах. Энэ хуулийн төслийг УИ-ын нэр бүхий зургаан гишүүн өргөн барьсан боловч өнөө хэр хэлэлцээгүй байна.
- Олон нийтийн радио, телевизийн хуульд хараат бус байдлыг баталгаажуулах, хариуцлагыг нэмэгдүүлэх, олон нийтийн хяналтыг дээшлүүлэх чиглэлээр нэмэлт өөрчлөлт хийх
- Хэвлэл мэдээллийн хэрэгслийн өмчлөл, ил тод байдал, төвлөрлийг зохицуулсан хууль батлах
- Өргөн нэвтрүүлгийн тухай хууль батлах
- Сэтгүүлчийн нууц эх сурвалжаа хамгаалах тухай хууль батлах

Иргэдийнхээ Үндсэн Хуулиар баталгаажсан үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэлтэй байх эрх, эрх чөлөөг дээдлэн хүндэтгэж, эрх зүйн зохих шинэтгэл хийх шаардлагатай байгааг Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын 60 жилийн ойг тохиолдуулан эрх баригчдад дахин сануулъя.

“Чөлөөт хэвлэл бол чөлөөт ард иргэд юм” хэмээн Чөлөөт Хэвлэлийн Хартийн үгээр илтгэлээ өндөрлөе.

Иргэн бидний эрх, эрх чөлөөг баталгаажуулж, хүний хөгжилд хөтөлсөн Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал мандтугай!

“XIX зүйл ба эрх зүйн орчин” дугуй ширээний ярилцлага
2008.12.08